



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

Журамд нэмэлт өөрчлөлт  
оруулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.9.2, 4.14.7, 10.2 дахь заатууд, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 7.3 заалтыг “Бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн саналыг үндэслэн, хүний нөөцийн эрдэм шинжилгээ, судалгааны чадавхыг нэмэгдүүлэх, багш нарт мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, мэргэжлийн хичээл орох, мэргэжлийн ном, сурах бичиг бичих, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зөвлөгч ба гүйцэтгэгчээр оролцуулах зорилгоор их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажилласан иргэнийг хөлсөөр ажиллуулах гэрээгээр Зөвлөх профессороор ажиллуулж болно” гэж өөрчлөн найруулсугай.
2. “Мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 7.3.1 заалтыг “ШУТИС-д “Зөвлөх профессор”-оор гэрээгээр ажиллах иргэнд тавих шаардлага, гэрээнд тусгах суурь нөхцөл нөхцлийг ШУТИС-ийн Захирлын тушаалаар батална” гэж өөрчлөн найруулсугай.
3. “Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам”-ын 7.1.4 заалтыг “Бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн саналыг үндэслэн, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажилласан иргэнийг хөлсөөр ажиллуулах гэрээгээр Зөвлөх профессороор ажиллуулж болно” гэж өөрчлөн найруулсугай.
4. Энэхүү тушаалыг 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс мөрдсүгэй.

ЗАХИРАЛ



Т.НАМНАН

367040415



## ШИНЖЛЭХ УХААҢ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/234

Улаанбаатар хот

### Мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, ШУТИС-ийн дүрмийн 4.14.7, 10.2 дахь заалт, ШУТИС-ийн захирлын зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлын тэмдэглэл, ажлын хэсгийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Х.Энхжаргал), Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Т.Намнан), Захиргаа, хүний нөөцийн газрын дарга (Н.Ганзориг), бүрэлдэхүүн сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Захирлын 2018 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/168 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг 2022 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс мөрдсүгэй.

ЗАХИРАЛ




Б.ОЧИРБАТ

367041378



ШУТИС-ийн захирлын 2021 оны 12 дугаар сарын  
14-ний өдрийн 1274 дугаар тушаалын хавсралт



	<b>МЭРГЭЖЛИЙН САЛБАР, ТЭНХИМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ</b> ШУТИС-ХН-ЖУ07	Эхний хэвлэлт	2015.02.05
		Өөрчилсөн огноо	2021.12.14
		Өөрчлөлтийн дугаар	3

# ШУТИС-ийн МЭРГЭЖЛИЙН САЛБАР, ТЭНХИМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

## Боловсруулсан:

Захиргаа, хүний нөөцийн газар  
Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн газар  
Ажлын хэсэг

## Хянасан:


Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээний алба

## Дэмжсэн:

ШУТИС-ийн ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

## Баталсан:

ШУТИС-ийн ЗАХИРАЛ



## АГУУЛГА

АГУУЛГА	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3
ЗУРГАА. МЭРГЭЖЛИЙН САЛБАР, ТЭНХИМИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	4
ДОЛОО. САЛБАР, ТЭНХИМИЙН ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА	5
НАЙМ. САЛБАР, ТЭНХИМИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ	6
ЕС. ГЭРЭЭТ БАГШ АЖИЛЛУУЛАХ	9



## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Их сургуулийн алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд салбар, тэнхимийн үйл ажиллагааг хөгжүүлэн төгөлдөржүүлэх, тэдгээрийг шинээр зохион байгуулах, татан буулгах, профессор, багшийг тухайн албан тушаалд ажиллуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2. Бүрэлдэхүүн сургуулийн салбар, тэнхимийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын онцлогт тохирсон зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлт хийх, профессор, багш нарын ажлын байранд тавигдах шаардлагын биелэлтийг хянаж, үнэлгээ дүгнэлт өгөх, ажлын үр дүнгээр албан тушаалын зэрэглэл, шатлалд өөрчлөлт оруулах, албан тушаалын орон тоог жил бүр шинэчлэн тогтоох замаар багш нарыг чадваржуулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.

## ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагаатай холбоотой аливаа үйл ажиллагааг зохицуулахад үйлчилнэ.
- 2.2. Тус журам нь ШУТИС-д салбар тэнхимд ажиллаж буй бүх багш, ажилтнуудад хамаарна.

## ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1. Боловсролын тухай хууль;
- 3.2. Дээд боловсролын тухай хууль;
- 3.3. ШУТИС-ийн дүрэм;
- 3.4. ШУТИС-ийн хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох хууль, журам.

## ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1. **Мэргэжлийн салбар (цаашид салбар гэх):** шинжлэх ухааны тодорхой салбараар төрөлжсөн, бакалавр, магистр, докторын хөтөлбөрүүдийг хариуцан хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа явуулах, түүний чанар, түвшинг их сургуулийн хүрээнд болон нийгмийн өмнө хариуцан ажиллах, бүтээлч сэтгэлгээ, шинэ санааг хөгжүүлэх, зохион бүтээх авьяас чадварыг дэмжин нийгэмд үйлчлэх үүрэг бүхий их сургуулийн зохион байгуулалтын үндсэн нэгж;
- 4.2. **Тэнхим:** тухайн бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрүүдэд тусгагдсан тодорхой суурь шинжлэх ухааны болон нийтлэг сургалтыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, нийгэмд үйлчлэх үндсэн үүрэг бүхий их сургуулийн зохион байгуулалтын үндсэн нэгж;
- 4.3. **ШУТИС-ийн нэг хичээлийн жилийн үргэлжлэх хугацаа:** тухайн жилийн 7 дугаар сарын 01-ний өдрөөс дараа жилийн 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаа;
- 4.4. **Хичээлийн жилийн намрын улирал:** тухайн жилийн 9 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хүртэлх хугацаа;





- 4.5. **Хичээлийн жилийн хаврын улирал:** тухайн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаа.

## **ТАВ. МЭРГЭЖЛИЙН САЛБАР, ТЭНХИМИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 5.1. Салбар, тэнхимийг шинэчлэн зохион байгуулах, шинээр байгуулах болон татан буулгах асуудлыг бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэж, Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 5.2. Салбар, тэнхим нь ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталсан албан тушаалтны бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.
- 5.3. Салбар, тэнхимийн эрхлэгч өөрийн үйл ажиллагаанд туслуулах зорилгоор профессор багш нарт тодорхой чиг үүргийг хуваарилан хариуцуулан ажиллуулж болно.
- 5.4. Эрдэм шинжилгээ, судалгааны үндсэн нэгж болох судалгааны профессорын багийг салбар, тэнхим болон бүрэлдэхүүн сургууль дунд байгуулж ажиллуулах ба үйл ажиллагааг холбогдох журмаар зохицуулна. Салбар, тэнхимийн багш нар судалгааны профессорын багт давхар харьяалагдах боломжтой ба салбар, тэнхимийн эрхлэгч судалгааны профессорын багийг давхар удирдахгүй.
- 5.5. Салбар, тэнхимийн хурлыг багш нарын гуравны хоёроос доошгүй ирцтэй хийж, хэлэлцэх асуудлыг олонхын саналаар батлан тэмдэглэл хөтөлнө. Санал тэнцсэн тохиолдолд салбар, тэнхимийн эрхлэгчийн саналаар шийдвэрлэнэ.
- 5.6. Салбар, тэнхимийн үйл ажиллагааны санхүүжилтийг бүрэлдэхүүн сургуулийн төсөвт тусгаж батална.
- 5.7. Салбар, тэнхимийн үйл ажиллагааны тайланг бүрэлдэхүүн сургуулийн Захирлын зөвлөлөөр хэлэлцэж дүгнэх ба салбар, тэнхимийн эрхлэгчийн ажлын үр дүнг тухайн салбар, тэнхимийн хамт олноор үнэлүүлж дүгнүүлнэ.
- 5.8. Салбарт харьяалагдах сургалтын хөтөлбөрүүд, салбар, тэнхимийн багш нарын тоо, сургалтын материаллаг бааз, лаборатори зэргээс хамаарч тухайн албан тушаалд харгалзах орон тоог ялгаатай тогтоох ба дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 5.8.1. Бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд ажиллах зөвлөх профессорын орон тоог тухайн жилд ШУТИС-ийн Захирал тогтооно.
- 5.8.2. Тухайн салбарт ажиллах профессорын орон тоог хариуцан хэрэгжүүлж буй ахисан түвшний сургалтын хөтөлбөрийн тоо, профессор багш нарын болон суралцаж буй оюутны тоотой уялдуулан ШУТИС-ийн Захирал тогтооно.
- 5.8.3. Тухайн салбарт ажиллах дэд профессорын орон тоо нь хариуцан хэрэгжүүлж буй бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрийн тоотой тэнцүү байна. Тухайн бакалаврын хөтөлбөрт хамаарах мэргэжлийн тоо 4 буюу түүнээс их байх тохиолдолд нэг дэд профессорын орон тоо нэмж болно.
- 5.8.4. Тэнхимийн нийт үндсэн багшийн тоо 30-аас бага үед 1 профессор, 1 дэд профессор, нийт үндсэн багшийн тоо 31 буюу түүнээс их үед 2 хүртэл профессор, 2 хүртэл дэд профессор ажиллуулж болно.



- 5.8.5. Ахлах багш, багш, дадлагажигч багшийн хувьд тухайн албан тушаалын орон тоог хязгаарлахгүй.
- 5.9. Салбар, тэнхимд гадаадын зочин профессор ажиллуулах асуудлыг ШУТИС-ийн Захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 5.10. Профессор багш нарын албан тушаалын ангилал, цалингийн шатлалыг жил бүрийн эхэнд ШУТИС-ийн Захирлын тушаалаар шинэчлэн батална.

## **ЗУРГАА. САЛБАР, ТЭНХИМИЙН ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 6.1. Салбар, тэнхим нь сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, нийгмийн үйлчилгээний үйл ажиллагаатай холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 6.1.1. Салбарын хувьд:
- 6.1.1.1. Салбар нь бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалт явуулах, хөтөлбөрийн үр дүн, чанарт байнгын дүн шинжилгээ, өөрийн үнэлгээ хийж, дотоодод болон олон улсын түвшинд магадлан итгэмжлүүлэх;
  - 6.1.1.2. Сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах болон шинэ хөтөлбөр нээх, хөтөлбөрийг зогсоох талаар хөтөлбөрийн дэд хороонд санал хүргүүлэх, хичээлийн стандартыг боловсруулах;
  - 6.1.1.3. Мэргэжлийн салбарын суралцагчдыг эрдэм шинжилгээний ажлын арга барилд сургах, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх, иргэний соёл төлөвшүүлэх, мэргэжлийн уралдаан, соёл, олон нийтийн ажил зохион байгуулах болон оюутны сайн дурын байгууллага, дугуйлан, клубыг дэмжин ажиллах;
  - 6.1.1.4. Сургууль-төгсөгч-ажил олгогчийн холбоог бэхжүүлж, төгсөгчдийг насан туршийн сургалтад хамруулах, тэдэнтэй тогтвортой хамтран ажиллах механизм бүрдүүлэх болон төгсөгчдийн мэргэжлийн чадвар болон сургалтын хөтөлбөрт санал авах, хамтарсан сургалт, судалгаа явуулах зэргээр ажил олгогчидтой хамтран ажиллах;
- 6.1.2. Тэнхимийн хувьд:
- 6.1.2.1. Тэнхим нь тухайн бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрүүдэд тусгагдсан тодорхой суурь шинжлэх ухааны хичээлийн стандартыг боловсруулах, сургалт явуулах;
  - 6.1.2.2. Сургалтын хөтөлбөрт тодорхой суурь шинжлэх ухааны хичээлтэй холбоотой өөрчлөлт оруулах талаар хөтөлбөрийн дэд хороонд санал хүргүүлэх;
  - 6.1.2.3. Суралцагчдыг эрдэм шинжилгээний ажлын арга барилд сургах, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх, иргэний соёл төлөвшүүлэх, уралдаан, олимпиад, соёл, олон нийтийн ажил зохион байгуулах;
- 6.2. Салбар, тэнхимийн нийтлэг чиг үүрэг, үйл ажиллагаа:
- 6.2.1. Салбар, тэнхимийн хөгжлийн чиг хандлага, үнэт зүйл, зорилго, зорилтыг урт ба дунд хугацаагаар төлөвлөх, бизнес болон стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах;
  - 6.2.2. Салбар, тэнхимийн үйл ажиллагааны төсвийн төлөвлөлтийн саналыг боловсруулах;





- 6.2.3. Суралцагчдыг суралцах таатай орчин болон сургалтын иж бүрэн материалаар хангах, сургалт, судалгааны материаллаг баазыг шинэчлэх, шинээр байгуулах, мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлага, заавар боловсруулах ажлыг нэгдсэн төлөвлөлттэй зохион байгуулах;
- 6.2.4. Профессор багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, багшлах бүрэлдэхүүнийг чанаржуулах, эрдэмжүүлэх, мэргэжлийн сургалт, заах арга зүйг сайжруулах ажлыг нэгдсэн удирдлагаар ханган зохион байгуулах;
- 6.2.5. Сургалтын бус үйл ажиллагаанаас орох орлогыг нэмэгдүүлэх, профессор багш нарын туршилт судалгаа явуулах орчин нөхцөлийг сайжруулах, эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтийн эх үүсвэр бий болгох;
- 6.2.6. Эрдэм шинжилгээний семинарыг судалгааны чиглэлээр тогтмол явуулах (улиралд 2-оос доошгүй), мэргэжлийн сургалт-заах арга зүй, эрдэм шинжилгээ, онол практикийн хурлыг зохион байгуулах, судалгааны үр дүнг дотоод болон гадаадад хэвлэн нийтлүүлэх;
- 6.2.7. Профессор багш болон салбарын бусад ажилтны ажлын чиг үүрэг, албан тушаалын зэрэглэл, шатлалыг тогтоох, өөрчлөх санал гаргах, багш, ажилтны гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, ёс зүйн болон сахилгын зөрчилтэй холбогдсон хариуцлага тооцох санал гаргах;
- 6.2.8. Нийгэм, олон нийтэд чиглэгдсэн, эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ, үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд явуулах;
- 6.2.9. Монгол улсын ба тодорхой салбарын урт, богино хугацааны хөгжлийн бодлого, төсөл, хөтөлбөр, боловсруулах, хэрэгжүүлэхэд хамтран оролцох, зөвлөгөө өгөх, төрийн болон холбогдох мэргэжлийн байгууллага, гадаад, дотоодын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний болон бизнесийн байгууллагатай түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 6.2.10. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, салбар, тэнхим, судалгааны профессорын багуудтай үйл ажиллагааг уялдуулан хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан сургалт, хөтөлбөр зохион байгуулах;
- 6.2.11. ШУТИС-ийн дүрэм, журамд өөрчлөлт оруулахтай холбоотой саналыг бүрэлдэхүүн сургуулиар дамжуулан гаргах;
- 6.2.12. Салбар, тэнхимийн түүхийн хуанлийг хөтлөх, холбогдох мэдээ тайлан, судалгааг цаг тухай бүр гаргах;
- 6.2.13. ШУТИС-ийн дүрэм, журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

## **ДОЛОО. САЛБАР, ТЭНХИМИЙН АЛБАН ТУШААЛЫН ЧИГ ҮҮРЭГ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**


- 7.1. Монгол улсын холбогдох хууль, бусад эрх зүйн актуудыг баримтлан, ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимд ажиллах багшийн албан тушаалын ангилал, албан тушаалын тодорхойлолт, “ШУТИС-ийн профессор багшид тавигдах нийтлэг шаардлага” зэргийг ШУТИС-ийн Захирал батална.
- 7.2. Салбар, тэнхимийн албан тушаалтнууд нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд албан тушаалын тодорхойлолтод заагдсан болон дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.






- 7.2.1. Салбарын эрхлэгч нь шинжлэх ухааны тодорхой чиглэлээр мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах, материаллаг баазыг бэхжүүлэх, салбарын хүний нөөцийн болон хөгжлийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх, багш, ажилтны гүйцэтгэлийг үнэлэх ба гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэл, суралцагчийн хөгжлийн асуудлыг хариуцан салбарын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 7.2.2. Тэнхимийн эрхлэгч нь сургалтын хөтөлбөрт тусгагдсан суурь шинжлэх ухааны сургалтыг хэрэгжүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах, баазыг бэхжүүлэх, тэнхимийн хүний нөөцийн болон хөгжлийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх, багш, ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, хүний нөөцийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх ба гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэн, тэнхимийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 7.2.3. Салбар, тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд тухайн мэргэжлийн чиглэлээр тухайн салбартаа нэр хүндтэй, хариуцсан нэгжийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн холбоог хөгжүүлэх, шинийг санаачилж багаар ажиллах чадвартай, доктор (Ph.D), дэд профессороос доошгүй эрдмийн зэрэг, цолтой эрдэмтдээс сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ШУТИС-ийн Захирал гурван жилийн хугацаатайгаар томилно. Ажилласан хугацааны ажлын үр дүн, хамт олны саналыг харгалзан тухайн хүнийг үргэлжлүүлэн дахин нэг удаа томилж болно.
- 7.3. Зөвлөх профессор нь салбар, тэнхимийн үйл ажиллагааг хөгжүүлэх, эрхлэгч болон багш нарт мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, онолын семинар явуулах, мэргэжлийн хичээл орох, зөвлөгөө өгөх, нэг сэдэвт бүтээл, ном, сурах бичиг бичих, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зөвлөгч ба гүйцэтгэгчээр оролцох, гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцох ажлыг гүйцэтгэнэ.
  - 7.3.1. ШУТИС-д ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, доктор (Ph.D), профессороос доошгүй эрдмийн зэрэг, цолтой эрдэмтдээс бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн салбар, тэнхимд зөвлөх профессороор нэг удаа хоёр жил хүртэл хугацаагаар ажиллуулж болно.
- 7.4. Салбарын профессор нь магистр, докторын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, эрдэм шинжилгээ, судалгааг хариуцах, ахисан түвшний сургалтад мэргэжлийн хичээл заах, сургалт, эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр ном, сурах бичиг, бүтээл бичиж туурвих ажлыг гүйцэтгэнэ. Тэнхимийн профессор нь бүх шатны мэргэжилтэн бэлтгэх сургалтад оролцох, ерөнхий суурь хичээлийн агуулгын онлайн нээлттэй эхийг хөгжүүлэх, мэргэжлийн хичээл заах, сургалт, эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр ном, сурах бичиг, бүтээл бичиж туурвих болон эрдэм шинжилгээ, судалгааны тодорхой чиглэлийг хариуцан ажиллана.
  - 7.4.1. Шинжлэх ухааны доктор (Sc.D) болон доктор (Ph.D)-ийн эрдмийн зэрэгтэй, профессор цолтой эрдэмтнийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн профессорын албан тушаалд ажиллуулна.





- 7.4.2. Доктор (Ph.D)-оос доошгүй эрдмийн зэрэгтэй, ~~дэд профессор~~ цолтой эрдэмтнийг судалгааны ажлын үр дүнг харгалзан профессорын албан тушаалд ажиллуулж болно.
- 7.4.3. Судалгаа шинжилгээний ажлын үр дүнгээр онцгой амжилт гаргасан, доктор (Ph.D)-оос доошгүй эрдмийн зэрэгтэй эрдэмтнийг ШУТИС-ийн Захирлын санал болгосны дагуу профессорын албан тушаалд ажиллуулж болно.
- 7.5. Дэд профессор нь бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцах, бүх шатны мэргэжилтэн бэлтгэх сургалт, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцох, удирдах, тухайн салбарын сургалтын материал, ном сурах бичгийн хангамжийг сайжруулах болон е-сургалтын үйл ажиллагааг хариуцна.
- 7.5.1. Доктор (Ph.D)-оос доошгүй эрдмийн зэрэгтэй, дэд профессор цолтой эрдэмтнийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн дэд профессорын албан тушаалд ажиллуулна.
- 7.5.2. Доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалаад ШУТИС-д хоёроос доошгүй жил амжилттай ажилласан залуу эрдэмтэн болон эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд таваас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан эрдэмтнийг дэд профессорын албан тушаалд ажиллуулж болно.
- 7.6. Ахлах багш нь бакалавр, магистр, докторын сургалтад хичээл заах, ном сурах бичиг, гарын авлага бичиж боловсруулах, сургалтын шинэ арга технологи нэвтрүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцох, удирдах үйл ажиллагааг хариуцна.
- 7.6.1. Их сургуулийн багшийн албан тушаалд үр бүтээлтэй ажилласан, докторын (Ph.D) зэрэгтэй багшийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн ахлах багшийн албан тушаалд ажиллуулна.
- 7.6.2. Багшийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалан багшлах ажилд шинээр орж байгаа залуу эрдэмтэн болон бусад их, дээд сургууль, коллежид ахлах багшаас доошгүй албан тушаалд ажиллаж байсан доктор (Ph.D)-ын зэрэгтэй багшийг ахлах багшийн албан тушаалд ажиллуулж болно.
- 7.7. Багш нь бакалавр, магистрын мэргэжилтэн бэлтгэх сургалтад хичээл заах, ном сурах бичиг, гарын авлага бичиж боловсруулах, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцоно.
- 7.7.1. Багшийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, үндсэн мэргэжлийн дагуу эрдэм шинжилгээний байгууллага, үйлдвэрлэл, бусад их, дээд сургууль, коллежид 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан хүнийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн багшийн албан тушаалд ажиллуулж болно.
- 7.7.2. Багшийн албан тушаалын шаардлагыг хангасан дадлагажигч багшийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн багшийн албан тушаалд дэвшүүлэн ажиллуулна.
- 7.8. Дадлагажигч багш нь бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцон хичээл зааж, багшлах ажлын дадлага, ур чадвар эзэмшинэ.
- 7.8.1. Багшийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, дадлагажигч багшийн албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага хангасан хүнийг дадлагажигч багшийн албан тушаалд нэг жилээс доошгүй хугацаагаар ажиллуулна.





- 7.9. Сургалтын мастер нь сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах техник хэрэгсэл, лабораторийг хариуцан, багш нарын ажилд дэмжлэг үзүүлэн, бакалаврын түвшний дээд боловсрол болон мэргэжлийн суурь ухааны хичээлийн хөтөлбөрийн дагуу лабораторийн хичээл заана.
- 7.10. Эрхлэгчийн туслах нь салбар, тэнхимийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад эрхлэгчийн өдөр тутмын үйл ажиллагаанд туслах, албан хэрэг хөтлөлтийг хариуцах, сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах анги танхим, зохион байгуулалтын нөхцөлийг бүрдүүлж, багш нарын ажилд дэмжлэг үзүүлж ажиллана.

### **НАЙМ. ГЭРЭЭТ БАГШ АЖИЛЛУУЛАХ**

- 8.1. ШУТИС-д ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад профессор, багшийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын туршлага, ур чадварыг өвлөн авах, залгамж халааг бэлтгэх, сургалтад оролцуулах, мэргэжлийн хичээл заалгах зорилгоор, мөн сургалтын үйл ажиллагааны явцад профессор багш нар хүрэлцээгүй тохиолдолд мэргэжлээрээ магистр болон түүнээс дээш зэрэгтэй, багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх дадлага, туршлагатай хүмүүсийг тухайн хичээлийн улиралд гэрээгээр ажиллуулж болно.
- 8.2. Тухайн хичээлийг хариуцсан салбар, тэнхимээс гэрээт багш ажиллуулах саналаа бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлын шийдвэр холбогдох баримт материалын хамт сургалтын асуудал эрхэлсэн захиргааны нэгжид хичээлийн жилийн тухайн улирал эхлэхээс өмнө хүргүүлнэ. Сургалтын асуудал эрхэлсэн захиргааны нэгж бүрэлдэхүүн сургуулиудаас ирсэн санал, материалыг хянаж нэгтгэн, ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 8.3. Бүрэлдэхүүн, харьяа сургууль, ШУТИС-Коосэн технологийн коллежийн захирал гэрээт багш нартай ажиллах нөхцөл, ажлын ачааллыг тусгасан гэрээг хичээлийн жилийн намрын улирал, хаврын улирал бүрийн эхэнд байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллана.
- 8.4. Гэрээт багшийн ажлын гүйцэтгэлийг тооцохдоо “ШУТИС-ийн профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-ыг баримтална.

---oOo---